5	ҮЭ-ийн авлага	131.9			131.9
7	НДШ-ийн авлага	147.0		147.0	-
8	Цалингийн авлага		18.0		18.0
	Дүн	1,238.7	18.0	147.0	1,109.7

Эх сурвалж: Баянхонгор аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газрын санхүүгийн тайлан

Тайлант жилийн төсвийн хөрөнгөөр худалдан авсан дүнгээр бараа материал нэмэгдсэн, шинээр баригдах "Багшийн хөгжлийн ордон"-той холбоотой 1,395.0 мянган төгрөгийн зардлыг урьдчилж төлсөнтэй холбоотой нөөцийн бараа данс нэмэгдсэн байна.

Тайлант онд төсвийн хөрөнгөөр 10,008.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж худалдан авч, аймгийн ИТХ-ын хуралдааны 2023 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн 14/30 дугаар тогтоолоор 9,000.0 мянган төгрөгийн суудлын автомашиныг нээлттэй дуудлага худалдаагаар худалдан борлуулж, санхүүгийн тайлангаас хассан, аймгийн ИТХ-ын хуралдааны 2023 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 17/66 дугаар тогтоолоор 63 нэрийн 60,567.8 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг акталж данснаас хассан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл тайлант үеийн үр дүнгийн 21,643.7 мянган төгрөгөөр буурч, 998,754.3 мянган төгрөг болсон байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 2,488,589.4 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас улсын төсвөөс авах санхүүжилтийг 893,391.2 мянган төгрөгөөр нэмэгдэж, 3,381,980.6 мянган төгрөг болсон нь ерөнхий боловсролын сургуулийн болон сургуулийн өмнөх боловсролын салбарт ажиллаж байгаа албан хаагчдаас тэтгэмж авах хүсэлтийг ирүүлсэнтэй холбоотой нэмэгдсэн байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тус байгууллагын төсвийг 2023 оны 09, 12 дугаар саруудад нэмж тодотгон, 3,561,690.9 мянган төгрөг болгож нэмэгдүүлсэн нь Засгийн газрын 241 дүгээр тогтоолоор цалин өссөн, багаж хэрэгсэл, тоног төхөөрөмж худалдан авахад 20,000.0 мянган төгрөг баталсан зэрэгтэй холбоотой байна.

Боловсрол, ШУ-ны бодлого удирдлага (71808) хөтөлбөрийн хүрээнд 2023 онд 672,653.2 мянган төгрөгийг баталснаас 670,153.3 мянган төгрөгийг зарцуулж, хэмнэлтийг төсөвт төвлөрүүлсэн байна.

Хүснэгт 3. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл (мянган төгрөгөөр)

№	Зориулалтын нэр код	ЭЗА нэр код	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
1	Үндсэн үйл ажиллагааны зардал 80801	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшуулал 210101	484,523.5	484,523.5	-
4		Ажил олгогчоос нийгмийн даатгал 210201	61,627.9	61,627.9	-
5		Байр ашиглалттай хол тогтмол зардал 2103	62,745.4	62,725.3	20.1
6		Хангамж, бараа материалын зардал 2104	5,800.9	5,627.9	173.0
7		Эд хогшил, урсгал засварын зардал 2106	29,802.0	29,800.4	1.6
8		Томилолт, зочны зардал 2107	2,000.0	2,000.0	-

9		Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээ төлбөр хураамж 210801	1,223.0	856.4	366.6
10		Бараа үйлчилгээний бусад зардаХичээл үйлдвэрлэлийн дадлага хийх 210902	13,442.7	13,442.6	0.1
11	Харуул, хамгаалалтын зардал 80219	Бусад нийтлэг АУТХураамж 210801	2,396.4	2,396.4	-
12	Ажил олгогчоос олгох тэтгэмж 80802	Тэтгэвэрт гарахад олгох тэтгэм 213207	7,738.6	6,600.1	1,138.5
13		Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал 213209	1,352.8	552.8	800.0

Эх сурвалж: Баянхонгор аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газрын төсвийн хэлбэлзэл

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 670,153.3 мянган төгрөг буюу нийт төлөвлөсөн зардлын 99.6 хувьтай байгаа нь нэг удаагийн тэтгэмж урамшуулал, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөрийг хэмнэсэнтэй холбоотой байна.

Тайлант онд ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн тэтгэвэрт гарахад олгох тэтгэмж, хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласны тэтгэмжид нийт 2,889,037.7 мянган төгрөг батлагдсанаас гүйцэтгэлээр 2,819,023.6 мянган төгрөгийг олгож, 70,014.1 мянган төгрөгийг хэмнэсэн байгаа нь зарим албан хаагчид шаардлагыг хангаагүйгээс тэтгэмж олгоогүйтэй холбоотой байна.

Хүснэгт 4. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл (мянган төгрөгөөр)

№	Хөтөлбөр нэр код	Зориулалтын нэр код	ЭЗА нэр код	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
1	Сургуулийн өмнөх боловсрол 71801	Ажил олгогчоос олгох тэтгэмж 80802	Тэтгэвэрт гарахад олгох тэтгэмж 213207	495,419.5	476,565.9	18,853.6
			Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласны тэтгэмж 213208	470,451.4	455,329.4	15,122.0
2	Ерөнхий боловсрол 71802	Ажил олгогчоос олгох тэтгэмж 80802	Тэтгэвэрт гарахад олгох тэтгэмж 213207	1,064,384.7	1,063,487.9	896.8
			Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласны тэтгэмж 213208	858,782.1	823,640.4	35,141.7

Эх сурвалж: Баянхонгор аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газрын төсвийн хэлбэлзэл

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд тус байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансаар нийт 87,257.8 мянган төгрөгийн орлого орсныг үйл ажиллагаанд зарцуулан, оны эцэст зардлаас хэмнэгдсэн 602.2 мянган төгрөгийг Сангийн яаманд төвлөрүүлсэн байна.

Хүснэгт 5. Нэмэлт санхүүжилтийн дансны орлого (мянган төгрөгөөр)

Байгууллагын нэр	Орлогын дүн	Орлогын тайлбар
Баянхонгор аймгийн Засаг даргын захирамжаар орон нутгаас хуваарилсан хөрөнгө	49,711.3	Улсын олимпиад, сургалт, хөтөлбөрийн зардал
Боловсролын ерөнхий газар	36,785.2	Олимпиад, сургалт, замын зардал
Аймгийн төвийн сургуулиуд	761.3	Сургалтын зардал
ДҮН	87,257.8	

Эх сурвалж: Баянхонгор аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газрын мөнгөн хөрөнгийн журнал

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Баянхонгор аймгийн БШУГ-т худалдан авах ажиллагаа байхгүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Баянхонгор аймгийн Боловсрол шинжлэх ухааны газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн тайлагналтай холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Должмаа гүйцэтгэж, хяналтыг ахлах аудитор М.Алтантуяа, газрын захирал, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Баянхонгор аймгийн Боловсрол шинжлэх ухааны газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 19-ний өдөр 45 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр тайлант жилийн батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэлж, материаллаг байдлын түвшнийг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны батлагдсан төсвийн 965,870.9 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 9,658.7 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 6,761.1 мянган төгрөгөөр тогтоосон.

Аудитыг гүйцэтгэх явцад аймгийн хэмжээний ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгүүдийн тэтгэвэрт гарахад албан хаагчдын хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласны мөнгөн тэтгэмж, өндөр настны тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмжийг батлагдсан төсөвт нэмж оруулах нь зүйтэй гэж үзсэн тул гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлыг нийт батлагдсан төсвийн 3,561,690.9 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 35,616.9 мянган төгрөгөөр тооцож, гүйцэтгэлийн материаллаг байдал тооцох хувийг 70 хувиар тооцож, 24,931.8 мянган төгрөгөөр шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжүүлэн ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Тус байгууллагад завсрын аудитыг гүйцэтгээгүй.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар "Өөрчлөлтгүй" дүгнэлт авч, аудитын тайлангаар 269,957.6 мянган төгрөгийн 4 шийдвэрийг өгсөн, хэрэгжилтийг санхүүгийн тайлангийн FAS системд оруулж, албан бичгээр хариуг ирүүлж, бүрэн хэрэгжүүлэн ажилласан байна.

Хүснэгт 6. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт (мянган төгрөгөөр)

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	-	-	-	-	-!
Албан шаардлага	2	269,957.60	2	269,957.60	100
Зөвлөмж	2	0	2	0	100
Залруулга					-
Нийт дүн	4	269,957.6	4	269,957.6	-

Эх сурвалж: Санхүүгийн тайлангийн FAS систем, ирүүлсэн холбогдох баримт, материал

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Аудитын цаг хугацаа богино, байгууллагын гүйлгээний цар хүрээ ихээс аймгийн хэмжээний ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгүүдийн тэтгэвэрт гарахад албан хаагчдын хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласны мөнгөн тэтгэмж, өндөр настны тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмжийг аудитад хамруулаагүй тул дараагийн аудитаар тусгайлан авч үзэх шаардлагатай байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 1,635.0 мянган төгрөгийн 2 алдаа¹ илэрснээс аудитын явцад санхүүгийн байдлын тайлангийн авлага, бараа материалд алдааг залруулав.

Залруулсан алдаа:

1. Байгууллагын дарга “Инжгеотех” ХХК-тай 2023 оны 08 дугаар сарын 08-ны өдөр “Инженер-геологийн судалгааны ажил гүйцэтгэх” 2,500.0 мянган төгрөгийн гэрээ байгуулж, 1,395.0 мянган төгрөгийг шилжүүлсэн байхад тайлант оны зардлаар тайлагнасан нь “Үнэлгээ ба хуваарилалт” батламж мэдэгдлийг хангахгүй тул санхүүгийн тайланд зардлыг бууруулан залруулсан.
2. Сангийн яамны э-тайланд санхүүгийн тайлан дахь авлагын эхний үлдэгдлийн 240.0 мянган төгрөгийг байгууллагын санхүүгийн тайланд эхний үлдэгдлээр тусгаагүй зөрсөн тул аудитаар авлагын эхний үлдэгдлийг нэмэгдүүлэн залруулсан.

Аудитаар нийт 22,701.4 мянган төгрөгийн 3 зөрчил² илэрснээс, 1,091.7 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, 18,048.7 мянган төгрөгийн 1 албан шаардлага хүргүүлж, 3,561.0 мянган төгрөгийн зөрчилд 1 зөвлөмж өглөө.

Нийт илрүүлсэн дээрх зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс бага тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өглөө.

5.1 Албан шаардлага

1. Санхүүгийн тайланд бүртгэлтэй өмнөх оны 1,091.7 мянган төгрөгийн авлагыг барагдуулах талаар төсвийн захирагч, нягтлан бодогч нар арга хэмжээ авч ажиллаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь “Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, 6.6.1 дэх “төсвийн захирагч нь түүнийг томилсон байгууллага, албан тушаалтны өмнө, эсхүл дээд шатныхаа төсвийн захирагчийн өмнө төсвийн талаар хариуцлага хүлээдэг байх” гэснийг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Өмнөх оны авлагыг барагдуулж ажиллах албан шаардлагыг хүргүүлэв.

2. Байгууллагын үндсэн хөрөнгөд 2017-2020 онуудад бүртгэсэн 7 нэр төрлийн 18,048.7 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн ашиглах жилийг -1 жилээр оруулснаас шалтгаалан, үндсэн хөрөнгөд хуримтлагдсан элэгдэл байгуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна”, Сангийн сайдын 2023 оны А/229 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын 10.21 дэх “Элэгдэл нь хөрөнгийн элэгдүүлэх дүнг түүний ашиглалтын хугацаанд хуваарилах системтэй хуваарилалт юм”, 10.24 дэх “Хөрөнгийн ашиглалтын хугацаа нь байгууллага тухайн хөрөнгийг ашиглахаар хүлээгдэж буй хугацаа, эсхүл тухайн хөрөнгийг

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

ашиглан үйлдвэрлэхээр хүлээгдэж буй бүтээгдэхүүний хэмжээ, түүнтэй адилтгах нэгж юм”, “Үндсэн хөрөнгийг ашиглахад бэлэн болсон үеэс эхлэн элэгдүүлнэ” гэснийг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Байгууллагын санхүүгийн тайланд бүртгэлтэй ашиглах жилийг буруу оруулсан үндсэн хөрөнгийн ашиглах жилийг байгууллагын НБББББ-т нийцүүлэн байгууллагын өмч хамгаалах зөвлөлөөр хэлэлцүүлэн бүртгэх албан шаардлагыг өгөв.

5.2. Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Хариуцлагатай холбоотой асуудал

Илрүүлэлт: Тайлант онд суудлын автомашинд 3,561.0 мянган төгрөгийн сэлбэг хэрэгсэл авахдаа байгууллагын өмч хамгаалах зөвлөл суудлын автомашины сэлбэгийг олгох талаар хэлэлцээгүй, байгууллагын дарга шийдвэр гаргаагүй, нярав сэлбэг хэрэгслийн тайланг дутуу тайлагнасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна”, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2018 оны 04 сарын 03-ны өдрийн 86 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Өмч хамгаалах зөвлөлийн үйл ажиллагааны нийтлэг журам”-ын 3.13-т “Өмч хамгаалах зөвлөл нь хуулийн этгээдийн тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийн ашиглалт, сэлбэг эд ангийг солих, барилга байгууламжийн их засвар хийх тохиолдолд батлагдсан норм стандартыг мөрдүүлэх, барилгын болон техникийн хувийн хэрэгт нь баяжилт хийлгэх зэргээр хяналт тавьж ажиллана” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Өмч хамгаалах зөвлөл, байгууллагын даргын шийдвэрийг үндэслэн худалдан авалтыг хийж, бараа материалын тайланг үнэн зөв тайлагнах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2024 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан нягтлан бодогчид талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл (мянган төгрөгөөр)

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлан дахь авлагын дүн Сангийн яамны Э-тайлангийн авлагын дүнгээс 240.0 мянган төгрөгөөр зөрүүтэй байна.	1	240.0					1	240.0				
2023 оны 12 дугаар сард Инжгеотех ХХК-тай 2,500.0 мянган төгрөгийн гэрээ байгуулж, 1,395.0 мянган төгрөгийг шилжүүлсэн байхад тайлант оны зардлаар тайлагнасан байна.	1	1,395.0					1	1,395.0				
Дүн	2	1,635.0	0	0	0	0	2	1,635.0	0	0	0	0

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл (мянган төгрөгөөр)

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Өмнөх оны санхүүгийн тайланд авлагаар бүртгэлтэй 1,091.7 мянган төгрөгийн авлагыг барагдуулаагүй байна.	1	1,091.7			1	1,091.7						
Байгууллагын үндсэн хөрөнгөд 2017-2020 онуудад бүртгэсэн 7 нэр төрлийн 18,048.7 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн ашиглах жилийг -1 жилээр оруулснаас шалтгаалан, үндсэн хөрөнгөд хуримтлагдсан элэгдэл байгуулаагүй байна.	1	18,048.7			1	18,048.7						
Байгууллагын өмч хамгаалах зөвлөл автомашины сэлбэгийг олгох талаар хэлэлцээгүй, байгууллагын дарга шийдвэр гаргаагүй, нярав сэлбэг хэрэгслийн тайланг дутуу тайлагнасан байна.	1	3,561.0					1	3,561.0				
Дүн	3	22,701.4	0	0	2	19,140.4	1	3,561.0	0	0	0	0

---oOo---



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 02 сарын 22 өдөр

Дугаар 22/1/00560238/ША
2024/96/НА СТА ТМЗ

Номгон

ЗӨРЧИЛ АРИЛГАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд тодорхойлсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газрын 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Байгууллагын үндсэн хөрөнгөд 2017-2020 онуудад бүртгэсэн 18,048,694 (Арван найман сая дөчин найман мянга зургаан зуун ерэн дөрвөн) төгрөгийн 7 нэр төрлийн үндсэн хөрөнгийн ашиглах жилийг -1 жилээр оруулснаас шалтгаалан, үндсэн хөрөнгөд хуримтлагдсан элэгдэл байгуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна”, Сангийн сайдын 2023 оны А/229 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын 10.21 дэх “Элэгдэл нь хөрөнгийн элэгдүүлэх дүнг түүний ашиглалтын хугацаанд хуваарилах системтэй хуваарилалт юм”, 10.24 дэх “Хөрөнгийн ашиглалтын хугацаа нь байгууллага тухайн хөрөнгийг ашиглахаар хүлээгдэж буй хугацаа, эсхүл тухайн хөрөнгийг ашиглан үйлдвэрлэхээр хүлээгдэж буй бүтээгдэхүүний хэмжээ, түүнтэй адилтгах нэгж юм”, “Үндсэн хөрөнгийг ашиглахад бэлэн болсон үеэс эхлэн элэгдүүлнэ” гэснийг зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4

5040068

D/2024-ASH

дүгээр зүйлийн 4.2.1.11 дэх “хууль, тогтоомж гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэснийг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Байгууллагын санхүүгийн тайланд бүртгэлтэй 18,048,694 (Арван найман сая дөчин найман мянга зургаан зуун ерэн дөрвөн) төгрөгийн 7 нэр төрлийн үндсэн хөрөнгийн ашиглах жилийг байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг үндэслэн, байгууллагын өмч хамгаалах зөвлөл, байгууллагын даргын шийдвэрээр ашиглах жилийг өөрчлөн, элэгдлийг байгуулж, нотлох баримтыг FAS системд оруулж, албан шаардлагын биелэлтийг 2024 оны 04 дүгээр сарын 16-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх¹

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж, хөрөнгийг нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт тусгасны дагуу бүртгэж, зөрчилгүй ажиллахыг Баянхонгор аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газрын дарга Ж.Алтанцэцэг, нягтлан бодогч Л.Оюунтуяа нарт даалгав^{2,3}.


АЛБАН ШААРДЛАГЫГ ӨГСӨН⁴

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:

Б.МӨНХБАТ

АХЛАХ АУДИТОР:

Б.ДОЛЖМАА



¹ Монгол Улс, Баянхонгор аймаг, Баянхонгор сум, Нутгийн удирдлагын ордон 3 давхар

² Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1 “Захиргааны актыг энэ хуульд заасан журмын дагуу мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор гомдлыг хянан шийдвэрлэх захиргааны байгууллагад гаргана.”

³ Монгол улсын ерөнхий аудиторовын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын 5.5 “Аудитад хамрагдагч нь аудитын тайлангийн төслийн өөрт холбогдох хэсэгтэй танилцах, санал өгөх, албан шаардлага, төлбөрийн акт, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөндсөн гэж үзвэл эрх бүхий албан тушаалтанд гомдол гаргах эрхтэй”

⁴ Төрийн аудитын тухай хуулийн 42.1-т энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 02 сарын 22 өдөр

Дугаар 23/2/АОСГ/238/БНА
2024/95/НА - СТА-ТМЗ

Номгон

ЗӨРЧИЛ АРИЛГАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд тодорхойлсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газрын 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Байгууллагын санхүүгийн тайланд бүртгэлтэй өмнөх оны авлагыг барагдуулах арга хэмжээ авч ажиллаагүйгээс 1,091,655 (Нэг сая ерэн нэгэн мянга зургаан зуун тавин таван) төгрөгийн авлагыг барагдуулаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", 6.6.1 дэх "төсвийн захирагч нь түүнийг томилсон байгууллага, албан тушаалтны өмнө, эсхүл дээд шатныхаа төсвийн захирагчийн өмнө төсвийн талаар хариуцлага хүлээдэг байх" гэснийг зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1.11 дэх "хууль, тогтоомж гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэснийг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Санхүүгийн тайлан дахь авлагын 1,091,655 (Нэг сая ерэн нэгэн мянга зургаан зуун тавин таван) төгрөгийг барагдуулан, нотлох баримтыг FAS систе

5040072

D/2024-ASH

оруулж, албан шаардлагын биелэлтийг 2024 оны 04 дүгээр сарын 25-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх¹

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Баянхонгор аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газрын дарга Ж.Алтанцэцэг, нягтлан бодогч Л.Оюунтуяа нарт даалгав^{2,3}.

АЛБАН ШААРДЛАГЫГ ӨГСӨН⁴:

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:

Б.МӨНХБАТ

АХЛАХ АУДИТОР:

Б.ДОЛЖМАА



¹ Монгол Улс, Баянхонгор аймаг, Баянхонгор сум, Нутгийн удирдлагын ордон 3 давхар

² Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1 "Захиргааны актыг энэ хуульд заасан журмын дагуу мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор гомдлыг хянан шийдвэрлэх захиргааны байгууллагад гаргана."

³ Монгол улсын ерөнхий аудиторовын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын 5.5 "Аудитад хамрагдагч нь аудитын тайлангийн төслийн өөрт холбогдох хэсэгтэй танилцах, санал өгөх, албан шаардлага, төлбөрийн акт, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөндсөн гэж үзвэл эрх бүхий албан тушаалтанд гомдол гаргах эрхтэй"

⁴ Төрийн аудитын тухай хуулийн 42.1-т энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно